

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/188/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага.....	18
4.4 Зөвлөмж.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/72
танай _____ -ны № _____ -Т

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц.ОДОНТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

19020287

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>22,839,517.20</u>	<u>24,117,452.60</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	22,839,517.20	24,117,452.60
354	Хангамжийн материал	22,839,517.20	24,117,452.60
35410	Бичиг хэргийн материал	446,800.00	631,100.00
35420	Аж ахуйн материал	702,000.00	1,291,350.00
35450	Барилгын засварын материал	500,000.00	-
35460	Хүнсний материал	2,325,450.00	4,023,225.00
35470	Бусад хангамжийн материал	18,865,267.20	18,171,777.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>495,096,823.20</u>	<u>471,454,866.04</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	495,096,823.20	471,454,866.04
392	Биет хөрөнгө	482,976,823.20	459,334,866.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	505,972,610.20	505,972,610.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(40,309,471.68)	(60,464,207.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,179,696.01	53,679,696.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,755,901.33)	(41,554,133.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,772,062.50	4,889,890.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,882,172.50)	(3,188,988.96)
393	Биет бус хөрөнгө	12,120,000.00	12,120,000.00
39301	Програм хангамж	628,000.00	628,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(628,000.00)	(628,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,120,000.00	12,120,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>517,936,340.40</u>	<u>495,572,318.64</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>517,936,340.40</u>	<u>495,572,318.64</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	517,936,340.40	495,572,318.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	232,742,753.55	232,742,753.55
51101	Өмч: - төрийн	232,742,753.55	232,742,753.55
512	Хуримтлагдсан үр дүн	(120,633,210.01)	(142,997,231.77)
51210	Өмнөх үеийн үр дүн	(100,578,835.93)	(120,633,210.01)
51220	Тайлант үеийн үр дүн	(20,054,374.08)	(22,364,021.76)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	405,826,796.86	405,826,796.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>517,936,340.40</u>	<u>495,572,318.64</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	406,653,513.12	379,634,920.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	355,720,952.00	326,999,750.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,586,352.00	433,350.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,586,352.00	433,350.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,586,352.00	433,350.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	352,134,600.00	326,566,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	352,134,600.00	326,566,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50,932,561.12	52,635,170.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,613,600.00	3,704,870.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,613,600.00	3,704,870.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,318,961.12	48,930,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,318,961.12	48,930,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	426,707,887.20	401,998,941.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	426,707,887.20	401,998,941.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	327,108,684.46	335,359,574.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,875,388.10	211,756,823.46
210101	Үндсэн цалин	198,151,524.10	206,036,371.84
210102	Нэмэгдэл	-	5,720,451.62
210104	Урамшуулал	5,723,864.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,708,789.16	28,604,561.27
210201	Тэтгэврийн даатгал	17,225,976.00	19,965,988.42
210202	Тэтгэмжийн даатгал	2,389,357.83	2,298,829.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,621,267.33	1,707,494.87
210204	Ажилгүйдлийн даатгал	419,018.00	421,113.37
210205	Эрүүл мэндийн даатгал	4,053,170.00	4,211,135.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,618,961.12	49,399,752.55
210301	Гэрэл, цахилгаан	1,939,961.12	1,236,780.11
210302	Түлш, халаалт	41,679,000.00	48,162,972.44
2104	Хангамж, бараа материалын зардал	4,875,396.00	5,108,989.60
210401	Бичиг хэрэг	916,600.00	523,000.00
210402	Тээвэр, шатахуун	159,996.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63,000.00	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		36,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,606,000.00	2,651,500.00
210408	Бараа материал акталсны зардал	2,129,800.00	1,498,489.60
2105	Нормативт зардал	22,718,170.00	12,876,990.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,304.00	65,000.00
210502	Хоол, хүнс	22,710,866.00	12,440,790.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		371,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,000,000.00

Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	-	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	28,000.00	-
210702	Дотоод албан томилолт	28,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	256,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	256,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,027,980.08	26,612,457.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	326,000.00	758,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	142,000.00	712,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,559,980.08	25,141,957.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,599,202.74	66,639,367.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,613,600.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,613,600.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	92,985,602.74	66,639,367.72
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	92,985,602.74	66,639,367.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(20,054,374.08)</u>	<u>(22,364,021.76)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(20,054,374.08)</u>	<u>(22,364,021.76)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	232,742,753.55	405,826,796.86	-100,578,835.93	537,990,714.48
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	232,742,753.55	405,826,796.86	-100,578,835.93	537,990,714.48
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-20,054,374.08	-20,054,374.08
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	232,742,753.55	405,826,796.86	-120,633,210.01	517,936,340.40
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	232,742,753.55	405,826,796.86	-120,633,210.01	517,936,340.40
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	232,742,753.55	405,826,796.86	-120,633,210.01	517,936,340.40
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-22,364,021.76	-22,364,021.76
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	232,742,753.55	405,826,796.86	-142,997,231.77	495,572,318.64

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	403,067,161.12	379,201,570.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	352,134,600.00	326,566,400.00	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	352,134,600.00	326,566,400.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	352,134,600.00	326,566,400.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50,932,561.12	52,635,170.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,613,600.00	3,704,870.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,613,600.00	3,704,870.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,318,961.12	48,930,300.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,318,961.12	48,930,300.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	401,177,271.12	377,701,570.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	401,177,271.12	377,701,570.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	301,578,068.38	311,062,202.28	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,744,194.89	211,682,520.70	
210101	Үндсэн цалин	141,367,620.53	176,429,216.27	
210102	Нэмэгдэл	44,756,654.36	35,253,304.43	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,044,000.00	-	
210104	Урамшуулал	12,575,920.00	-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,839,982.37	28,678,864.03	
210201	Тэтгэврийн даатгал	17,178,372.11	20,246,103.81	
210202	Тэтгэмжийн даатгал	2,174,283.34	2,112,399.88	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,703,903.03	1,702,325.62	
210204	Ажилгүйдлийн даатгал	434,857.30	419,821.41	
210205	Эрүүл мэндийн даатгал	4,348,566.59	4,198,213.31	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,818,961.12	49,598,952.55	
210301	Гэрэл, цахилгаан	1,939,961.12	1,236,780.11	
210302	Түлш, халаалт	41,679,000.00	48,162,972.44	
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	199,200.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	1,418,600.00	3,062,300.00	
210401	Бичиг хэрэг	80,000.00	100,000.00	
210402	Тээвэр, шатахуун	160,000.00	200,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63,000.00	200,000.00	
210404	Ном, хэвлэл	72,300.00	72,300.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		300,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,043,300.00	2,190,000.00	
2105	Нормативт зардал	24,551,230.00	15,703,565.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,000.00	65,000.00	
210502	Хоол, хүнс	24,069,230.00	14,138,565.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	1,500,000.00	

Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	28,000.00	-
210702	Дотоод албан томилолт	28,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	256,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	256,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,421,100.00	1,836,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	326,000.00	598,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,095,100.00	1,238,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,599,202.74	66,639,367.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,613,600.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,613,600.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	92,985,602.74	66,639,367.72
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	92,985,602.74	66,639,367.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,889,890.00	1,500,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,889,890.00	1,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,889,890.00	1,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,889,890.00	1,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,889,890.00	1,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,889,890.00)	(1,500,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	375,496,700.00	311,393,549.73	64,103,150.27	82.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	375,496,700.00	311,393,549.73	64,103,150.27	82.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,496,700.00	311,393,549.73	64,103,150.27	82.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,790,400.00	211,682,520.70	37,107,879.30	85.08
210101	Үндсэн цалин	157,334,600.00	176,429,216.27	(19,094,616.27)	112.14
210102	Нэмэгдэл	55,687,300.00	35,253,304.43	20,433,995.57	63.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,800,000.00	-	8,800,000.00	-
210104	Урамшуулал	26,968,500.00	-	26,968,500.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,586,700.00	28,678,864.03	4,907,835.97	85.39
210201	Тэтгэврийн даатгал	23,635,800.00	20,246,103.81	3,389,696.19	85.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,488,900.00	2,112,399.88	376,500.12	84.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,991,000.00	1,702,325.62	288,674.38	85.50
210204	Ажилгүйдлийн даатгал	497,900.00	419,821.41	78,078.59	84.32
210205	Эрүүл мэндийн даатгал	4,973,100.00	4,198,213.31	774,886.69	84.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,430,300.00	48,430,300.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	3,772,200.00	1,236,780.11	2,535,419.89	32.79
210302	Түлш, халаалт	44,458,100.00	46,994,319.89	(2,536,219.89)	105.70
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	199,200.00	800.00	99.60
2104	Хангамж, бараа материалын зардал	3,062,300.00	3,062,300.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	100,000.00	100,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	200,000.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	72,300.00	72,300.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,000.00	2,190,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	37,691,000.00	15,703,565.00	21,987,435.00	41.66
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,000.00	65,000.00	-	100.00
210502	Хоол, хүнс	36,126,000.00	14,138,565.00	21,987,435.00	39.14
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.00
2107	Томиллолт, зочны зардал	100,000.00	-	100,000.00	-
210702	Дотоод албан томиллолт	100,000.00	-	100,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,336,000.00	3,336,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,098,000.00	2,098,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,238,000.00	1,238,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	375,496,700.00	311,393,549.73	64,103,150.27	82.93

Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	326,566,400.00	262,463,249.73	64,103,150.27	80.37
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	326,566,400.00	262,463,249.73	64,103,150.27	80.37
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,930,300.00	48,930,300.00	-	100.00
122005	Орон нутгийн төсвөөс	48,930,300.00	48,930,300.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	20.00	20.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

				/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,168,652.55	1,168,652.55	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,168,652.55	1,168,652.55	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,168,652.55	1,168,652.55	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,168,652.55	1,168,652.55	
210302	Түлш, халаалт	1,168,652.55	1,168,652.55	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,704,870.00	3,704,870.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,704,870.00	3,704,870.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,704,870.00	3,704,870.00	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хөрөнгө бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэг нь хүүхдийн сэтгэл санааны аятай байдлыг дэмжин, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлж, хүүхдэд ээлтэй цэцэрлэг болохыг эрхэм зорилгоо болгон анхан шатны боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг юм.

Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэгийн Эрхлэгчийн тушаалаар томилогдсон дотоод хяналтын баг нь 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 ажил хийгдэхээр төлөвлөснийг тайлант хугацаанд бүрэн гүйцэтгэж, дотоод хяналтыг үр дүнг улирал бүр гарган тайлагнан ажилласан.

Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэг нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг.

Тайлант онд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 375,496.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,632.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,224.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Гүүксофт” ХХК-ний “Dynamic” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 375,496.7 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 3,704.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 377,701.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 433.4 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 19,543.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 18,698.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна

Авлага, өглөгийн талаар:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дангүй байна. Бараа материал 24,117.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 471,454.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага			-
Урьдчилгаа			-
Бараа материал	22,839.50	24,117.50	1,278.00
Үндсэн хөрөнгө	495,096.80	471,454.80	(23,642.00)
Нийт хөрөнгө	517,936.30	495,572.30	(22,364.00)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	517,936.30	495,572.30	(22,364.00)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	517,936.30	495,572.30	(22,364.00)

Бараа материалын дансны үлдэгдэл 24,117.5 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 1,278.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 471,454.8 мянган төгрөг болж 23,642.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 495,572.3 мянган төгрөг болж 22,364.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 375,496.7 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 375,496.7 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 375,496.7 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвөөс 375,496.7 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 311,393.5 мянган төгрөгийг батлагдсан

төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 64,103.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 311,393.5 мянган төгрөг буюу 82.9 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 1,168.7 мянган төгрөг төвлөрч, урсгалд зардалд 1,168.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нэмэгдэж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглагдах боломжгүй 882.2 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор акталсан.

3.8 Аудитын гол асуудал

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 4 нэр төрлийн 1,489.5 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй, биет бус хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 4 нэр төрлийн 628.0 мянган төгрөгийн үнэ бүхий, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагддаггүй биет бус хөрөнгө бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 136 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 9 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 406.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3,497.9 мянган төгрөгийн зөрчил арилгах 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 1 алдаа зөрчил давтан гарч байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,357.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 240.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 628.0 мянган төгрөгийн албан шаардлага, 1,489.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа гараагүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 240.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд Үндсэн ажлаас гадуур давхар хөдөлмөр эрхэлдэг 1 албан хаагчид ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулан тооцсоны улмаас нийт 240.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгасан нь: ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ" гэсэнтэй нийцэхгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн дутуу суутгасан ХХОАТ-ыг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар 628.0 мянган төгрөгийн зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 4 нэр төрлийн 628.0 мянган төгрөгийн үнэ бүхий, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагддаггүй биет бус хөрөнгө бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэнтэй нийцэхгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн хөрөнгийн тооллогыг бодитой гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 4 нэр төрлийн 1,489.5 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 273 тоот тогтоол, УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй, "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 136 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 9 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэг	4	2,357.5	-	-	1	240.0	1	628.0	2	1,489.5

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn